



ХЭНТИЙ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АРВАН ГУРАВДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 03

Чингис хот

□ 2020 онд ахуйн болон тусгай зориулалтаар
агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний
дээд хязгаарыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арван гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2020 онд ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг нэгдүгээр хавсралтаар, тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан агнуурын бүс нутгийн агнуурын нөөцөд тохируулан агнуурын амьтныг агнуулж, бариулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгаль орчны хороо /Б.Дархантөр/-нд үүрэг болгосугай.

ДАРГА


Л.БАТСАЙХАН

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
 2020. оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
 13 дугаар Хуралдааны 03 дугаар
 тогтоолын 01 дүгээр хавсралт

2020 онд ахуйн зориулалтаар агнах,
 барих агнуурын амьтдын тоо хэмжээний дээд хязгаар /толгой/

№	Сумын нэр	хөхтөн				сэлүүртэн											Нийт загас
		цагаан зээр	зэрлэг гахай	бор гөрөөс	саарал чоно	амарын зэвэг	ердийн зэвэг	амарын цурхай	улаан живэрт	амарын сугас	цулбуурт	гутаар	мөнгөлөг хэлтэг	булуу цагаан	Хадран		
1	Галшар	10															
2	Баянхутаг	2															
3	Баянмөнх	5								5	5	5	5			20	
4	Дэлгэрхаан									10	10	5	10	5		40	
5	Дархан	5															
6	Жаргалтхаан	3															
7	Цэнхэрмандал		1	2						4	3	3				10	
8	Өмнөдэлгэр		7		1												
9	Батширээт		15	10	5	20	150	110	20	15	10	15	20	10	30	400	
10	Биндэр		5	10	4	18	140	90	15	4	5	10	5	4		291	
11	Баян-Адрага					20	150	80	15	5	5	3				278	
12	Дадал		7	3		10	100	80	10	5	5	5				215	
13	Норовлин					18	140	80	15	5	5	3				266	
14	Батноров	10															
15	Хэрлэн						5	5	5	15	15	5	5	5		60	
16	Баян-Овоо	10				5					5	5	5			20	
17	Бор-Өндөр	5															
18	Мөрөн	2															
	НИЙТ	52	35	25	10	91	685	445	80	68	68	59	50	24	30	1600	

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
 13- дугаар хуралдааны 03 дугаар
 тогтоолын 02 дугаар хэвсрэлт



2020 онд тусгай зориулалтаар агнах,
 барих агнуурын амьтдын тоо хэмжээний дээд хязгаар /толгой/

№	Сумын нэр	Хөхтөн				Сэлүүртэн		Жигүүртэн						
		Угалз	Цагаан зээр	Бор гөрөөс	Саарал чоно	Тул	Бусад загас	Ятуу	Хар хур	Нургийн сойр	Хондон ангир	Анхидал ангир	Хөтүү	Нийт шувуу
1	Галшар		5											
2	Баянхутаг	1	5											
3	Баянмөнх		5											
4	Дэлгэрхаан	1												
5	Дархан													
6	Жаргалтхаан													
7	Цэнхэрмандал													
8	Өмнөдэлгэр			2					10					10
9	Батширээт					16	160	50	15	10	30	30	30	165
10	Биндэр			5	5	16	160	70			70			140
11	Баян-Адрага					16	160							
12	Дадал					16	160							
13	Норовлин					16	160							
14	Батноров													
15	Хэрлэн													
16	Баян-Овоо													
17	Бор-Өндөр													
18	Мөрөн	1												
	нийт	3	15	7	5	80	800	120	25	10	100	30	30	315

